# ХӨВСГӨЛ АЙМГИЙН
# ЦАГААН-УУЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ
# ТОГТООЛ

2014 оны 01 сарын 27 өдөр Дугаар 03 Шарга

Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, хяналтыг сайжруулж төсөлд шалгуур тогтоох тухай

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 04 дүгээр сарын 27 ны өдрийн 134 дүгээр тогтоолын хавсралт "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, ханалт тавих журам" –ыг үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаас **ТОГТООХ НЬ:**

**1.** "Сум хөгжүүлэх сангаас олгох зээлийн гэрээний загвар"-ыг 1 дүгээр хавсралт, "Сум хөгжүүлэх сангаас зээл авахад байгуулах барьцаа хөрөнгийн гэрээний загвар"-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус батлсугай.

**2.** Сумын эдийн засаг, нийгмийн хөгжлийн байдлыг харгалзан 2014 онд "Сум хөгжүүлэх сан"-аас олгох зээлийн хүүгийн хэмжээг сарын 0,25 хувь буюу жилийн 3 хувиар, зээлийн гэрээ зөрчсөн бол торгуулийн /нэмэгдүүлсэн/ хүүг сарын 2 хувь буюу жилийн 24 хувиар тогтоосугай.

**3.** Тус сангаас нэг төсөлд олгогдох зээлийн доод хэмжээг 20,0 сая төгрөгөөр, дээд хэмжээг 60 сая төгрөгөөр тогтоосугай.

**4.** Зээл хүсч буй төсөлд нийт хөрөнгийн 80 хүртэлх хувийг тоног төхөөрөмж, барилга байгууламжид зарцуулах шалгуурыг тогтоосугай.

**5.** Зээлийн барьцаанд үл хөдлөх хөрөнгө , мал, машин, төслөөр оруулж ирэх тоног төхөөремжийг барьцаалах, үнэлгээг зах зээлийн үнэлгээний 70 хувиас илүүгүй байхаар тооцсугай.

**6.** Тус хөрөнгөөр зээл олгохтой холбогдуулан тус сумын хөгжлийн тэргүүлэх чиглэлийг дараахи байдлаар тогтоосугай.

- Дахин боловсруулах үйлдвэр
- Барилгын материалын үйлдвэр
- Малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэр
- Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл
- Хатуу, зөөлөн оёдлын үйлдвэр
- Газар тариалан, жимсний аж ахуй
- Байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл

**7.** Тогтоолын биелэлтийг хангаж "Сум хөгжүүлэх сангийн хөрөнг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам"-д заагдсан эрх, үүргээ хэрэгжүүлэн төслийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сумын засаг дарга /Д. Түмэнбаярт/, Сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлт, тайлагналтад хяналт тавих ажлын хэсгийн ахлагч /Ча.Өнөржаргал/ нарт даалгасугай.

**8.** Тогтоолын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Л.Сэрсмаа/-д үүрэг болгосугай.

**ДАРГА Ч.АЗБАЯР**

ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2014 оны 01-р сарын 27-ны өдрийн
03 тоот тогтоолын 1 дүгээр хавсралт

# СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГААС ОЛГОХ ЗЭЭЛИЙН ГЭРЭЭ

20.. он...сар...өдөр Дугаар...

## Нэг. Ерөнхий зүйл

**1.1.** Энэхүү зээлийн гэрээгээр сумдад жижиг, дунд үйлдвэр шинээр байгуулах, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, өргөтгөх, сэргээх, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр төсөл боловсруулан шалгарсан иргэн, аж ахуйн нэгжид Сум хөгжүүлэх сангаас зээл олгохтой холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

**1.2.** Нэг талаас **Хөвсгөл** аймгийн **Цагаан-Уул** сумын **Засаг даргын тамгын газрыг** төлөөлж Засаг дарга **Дамдинрагчаа** овогтой **Түмэнбаяр** /цаашид "зээлдүүлэгч" гэх/ нөгөө талаас **Хөвсгөл** аймгийн **Цагаан-Уул** сумын ...... дугаар багийн иргэн, аж ахуйн нэгж /..................../-ийг төлөөлж ...................... овогтой ........................ /цаашид "зээлдэгч" гэх, хамтад нь "талууд" гэх/ нар Монгол Улсын Иргэний хуулийн 281-286 дугаар зүйлд заасныг үндэслэн ............................................................ /тоогоор, үсгээр/ төгрөгийн зээлийг дор дурдсан нөхцөлөөр олгохоор харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

**1.3.** Сангийн хөрөнгөөс зээл авахаар зээлдэгчийн шалгарсан төсөл нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.

## Хоёр. Зээлдэгч иргэн, аж ахуйн нэгжийн эрх, үүрэг

**2.1**.Сангаас олгох(..................)/.............................................................................../ /тоогоор, үсгээр/ төгрөгийн зээлийг Засгийн газрын 2011 оны 134 дүгээр тогтоолоор баталсан "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам"-ын 1.5-д заасны дагуу ........................................................................................ зориулалтаар зарцуулна.

**2.2.** Зээлийн үндсэн төлбөрийг хүүгийн хамт "Зээлийн эргэн төлөлтийн хуваарь"-ийн дагуу төлж дуусгана. Зээлийн эргэн төлөлтийн хуваарьт Талууд гарын үсэг зурж, баталгаажуулан гэрээнд хавсаргана.

**2.3.** Зээлдэгч зээлийн үндсэн хүүг сарын 0,25 хувь, жилийн 3 хувиар тооцож, сар бүрийн эхний 7 хоногийн ажлын өдөрт багтаан Төрийн сангийн 171655406 тоот дансанд төлнө.

**2.4.** Энэхүү гэрээний 2.2-т заасан зээлийн эргэн төлөлтийн хуваарьт заасан хугацаанд зээлийн үндсэн төлбөрийг төлөөгүй, эсхүл зээл төлөх эцсийн хугацаа хэтэрсэн бол зээлийн хугацаанд төлөгдөөгүй үлдэгдэлд хүүг 2 хувиар тооцож төлнө.

**2.5.** Гэрээнд заагдсан эрх үүргээ хэрэгжүүлээгүй нь хяналт шалгалтын үед илрэн зээлдүүлэгч гэрээг цуцалсан бол шаардсан хугацаанд зээлийг бүрэн барагдуулах.

**Гурав. Зээлдүүлэгчийн эрх, үүрэг**

**3.1.**Төсөл хэрэгжүүлэхэд зориулан (.....................) (.........................................................) /тоо, үсгээр /төгрөгийн зээлийг сарын 0,25 хувь, жилийн 3 хувийн хүүтэйгээр олгоно.

**3.2.** Зээлийн хөрөнгийг зээлдэгч иргэн, аж ахуйн нэгжийн ..............................банк дахь ................................ дансанд шилжүүлнэ.

**3.3.** Авсан зээл, түүний хүү, торгуулын төлбөрийг энэхүү гэрээнд заасан хугацаанд төлөөгүй тохиолдолд зээлдэгчийн банкин дахь данснаас үл маргах журмаар төлүүлэх, зохих журмын дагуу зээлийг төлүүлэх шаардлагатай бусад арга хэмжээ авна.

**3.4.** Гэрээний үүргийн биелэлтийг хангуулах, зээл, хүүгийнтөлөлтөд хяналт тавина.

**3.5.** Зээлдэгчийн хэрэгжүүлж байгаа төслийн явц, байдалтай тухай бүр танилцана.

**3.6.** Зээлийн эргэн төлөлт, хүүгийн орлогыг сангийн дансанд төвлөрүүлнэ.

**Дөрөв.Гэрээ дуусгавар болох, цуцлах**

**4.1.** Зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлбөр бүрэн төлөгдөж дууссан бол гэрээ дуусгавар болно

**4.2.**Зээлдэгч гэрээг цуцлах хүсэлт гаргаж зээлийн төлбөрийг барагдуулсан бол гэрээ дуусгавар болсонд тооцно.

**4.3.** Зээлдэгч гэрээнд заагдсан эрх үүргээ хэрэгжүүлээгүй нь хяналт шалгалтын үед илрэн ажлын хэсэг Гэрээг цуцлах дүгнэлт гаргасан бол Зээлдүүлэгч тал гэрээг цуцалж Зээлийн болон Барьцааны гэрээнд заагдсан эрх, үүргийн дагуу төлбөрийг барагдуулах арга хэмжээ авна.

**Тав.Маргааныг шийдвэрлэх**

**5.1.**Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурж, баталсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

**5.2.**Гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг оролцогч талууд харилцан зөвшөөрснөөр шийдвэрлэнэ.

**5.3.** Энэхүү гэрээтэй холбогдсон аливаа маргаантай асуудлыг хоёр тал харилцан тохиролцож шийдвэрлэх бөгөөд ийнхүү шийдвэрлэх боломжгүй бол асуудлыг шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭНИЙ ТАЛ:

ЗЭЭЛДҮҮЛЭГЧ: СУМЫН ЗАСАГ ДАРГА: ......................../Д.ТҮМЭНБАЯР/

ЗЭЭЛДЭГЧ: ........................................
.................................... /......................./

----------------------oOo---------------------

Сум хөгжүүлэх сангаас зээл олгох
20 . . он . . сар . . өдрийн . . . дугаар
гэрээний хавсралт

## ЗЭЭЛИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТИЙН ХУВААРЬ

Зээлдэгчийн нэр: .............................. Хугацаа: 36 сар

Банкны нэр: ...................... Дансны дугаар: ...............................

Батлагдсан огноо: ............................

Олгосон зээл: .................................... Олгогдсон огноо: ...........................

| № | Төлбөр хийх огноо | Төлбөр | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Хоног | Хүү /0.25%/ | Үндсэн зээл | Эргэн төлөлт /бүгд/ | Үлдэгдэл |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | |
| Нийт: | | | | | | |

ГЭРЭЭНИЙТАЛ:

ЗЭЭЛДҮҮЛЭГЧ: СУМЫН ЗАСАГ ДАРГА

................................/Д.ТҮМЭНБАЯР/

ЗЭЭЛДЭГЧ: ................................................

.............................................../............................../

-----------------------------------oOo-----------------------------------

ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2014 оны 01-р сарын 27-ны өдрийн
03 тоот тогтоолын 2 дугаар хавсралт

## ЗЭЭЛИЙН БАРЬЦААНЫ ГЭРЭЭ

20 .. оны ...сар .... өдөр Дугаар №.....

### Нэг. Ерөнхий зүйл

**1.1.** Энэхүү гэрээгээр Зээлдэгч, Зээлдүүлэгчийн хооронд ......оны ... сарын.... өдөр байгуулсан .... дугаар зээлийн гэрээ, түүний нэмэлт гэрээний үүргийн гүйтэтгэлийг хангуулах, барьцаалуулагчийн хөрөнгө, түүнтэй холбоотой эрхийг барьцаалах, барьцааны зүйлийг үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуульд заасны дагуу худалдан борлуулж зээлийн төлбөрийг барагдуулахтай холбогдсон харилцааг зохицуулна.

**1.2.** Зээлдүүлэгчийг төлөөлж **Хөвсгөл** аймгийн **Цагаан-Уул** сумын Засаг дарга **Дамдинрагчаа** овогтой **Түмэнбаяр /барьцаалагч гэх/**, Зээлдэгчийг төлөөлж **Хөвсгөл** аймгийн **Цагаан-Уул** сумын .... дугаар багийн иргэн ..................... регистрийн дугаартай,............................ ургийн овогтой ..................-ийн ..................... нь /барьцаалуулагч гэх/ нар нь хүсэл ашиг сонирхолоо бүрэн илэрхийлж дор дурьдсан нөхцөлүүдийн талаар харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

**1.3.** Энэ гэрээ нь зээлийн гэрээний үүрэг бүрэн биелэгдэх хүртэлх хугацаанд хүчин төгөлдөр байж, зээлдэгч зээлийн гэрээний үүргээ бүрэн биелүүлж, төлбөр барагдсанаар дуусгавар болно.

### Хоёр. Барьцааны зүйл, Барьцааны эрх

**2.1** Энэ гэрээнд Талууд гарын үсэг зурж баталснаар хүчин төгөлдөр болж барьцааны эрх үүснэ.

**2.2** Барьцаалуулагч нь Зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар дараахь хөрөнгө, түүний бүрдэл хэсэг, дагалдах зүйл, хөрөнгийг барьцаалуулсан болно.

| № | Барьцааны зүйлийн байршил, зориулалт, талбайн хэмжээ чанар байдал | Улсын бүртгэлийн дугаар, гэрчилгээний дугаар | Өмчлөх эрхийг бүртгэсэн байгууллагын нэр, огноо | Барьцааны зүйлийн үнэ |
|---|---|---|---|---|
| 1 | | | | |
| 2 | | | | |

00058

| | | | | |
|---|---|---|---|---|
| 3 | | | | |
| 4 | | | | |

**2.3** Зээлдэгч гэрээний хугацаанд зээл төлөөгүй тохиолдолд үндсэн зээл, зээлийн хүү, нэмэгдүүлсэн хүү, барьцааны зүйлийг худалдан борлуулахад гарсан зардал, шүүхийн зардал зэрэг төлбөрийг дээрхи 2.2-т байгаа барьцаагаар нөхөн төлүүлнэ.

**2.4** Барьцаалагчийн шаардлагаар дараахь тохиолдолуудад барьцаалуулагч нь нэн даруй барьцааны зүйл болон түүний тодорхой хэсгийг нэмэгдүүлнэ.

**2.4.1** Аливаа шалтгаанаар барьцаалуулагчийн хөрөнгө өмчлөх эрх бүхэлдээ болон хэсэгчлэн цуцлагдах.

**2.4.2** Барьцааны зүйл бүхэлдээ болон хэсэгчлэн үрэгдэх эсвэл бүрэн бүтэн байдалд нь харшлах нөхцөл үүсэх.

**2.5** Зээлийн гэрээний зүйл бүрэн биелэгдэх хүртэл барьцааны зүйлийн бүрэн бүтэн байдлыг хангаж зээлдүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр барьцааны зүйлийг бүхэлд нь буюу хэсэгчлэн өмчлөх, захиран зарцуулах, эзэмших, ашиглах эрхийг бусдад шилжүүлэхгүй байна.

**2.6** Барьцаалуулагч нь зээлийн гэрээ дуусгавар болох хүртэлх хугацаанд барьцааны зүйлтэй холбоотой аливаа мэдээлэл лавлагааг эрх бүхий байгууллага, бусад этгээдээс авах эрх барьцаалагчид байна.

**2.7** Барьцаагаар хангагдах үүрэг бүрэн биелэгдэх хүртэлх хугацаанд барьцааны зүйлтэй холбоотой баримт бичиг, барьцаалагч шаардсан бол өгөх, барьцааны зүйлийг газар дээр нь хэдийд ч шалгах эрх гэрээ байгуулсан өдрөөс нээгдэнэ.

**2.8** Ирээдүйд бий болох хөрөнгө барьцаалж болно.

## Гурав. Барьцаалуулагчийн эрх, үүрэг

**3.1** Зээлийн төлж дуусах хүртэл хугацаанд барьцаанд байгаа зүйлийг арчлан хамгаалах, чанар байдлыг хэвийн хэмжээнд байлгаж өртгийг нь бууруулахгүй байх

**3.1.1** Барьцааны зүйлийг барьцаалагч барьцаалуулагчийн хооронд байгуулсан гэрээ, хууль тогтоомжийг зөрчин бусдад барьцаалах, устгах, үрэгдүүлэх, гэмтээх зэргээс шалтгаалан зээлээ төлж чадахгүй болсон тохиолдолд барьцаалуулагч бусад эд хөрөнгөө худалдан борлуулж, шаардсан хугацаанд зээлийн гэрээний үүргийг бүрэн барагдуулна.

**3.1.2** Барьцааны зүйлийг даатгуулсан үед эрсдэл учиран даатгалын нөхөн төлбөр авах болбол зээлийн гэрээний үүргийг тэргүүн ээлжинд гүйцэтгэнэ.

3.1.3 Бусдын хөрөнгийг зөвшөөрөлгүйгээр хууль бусаар барьцаалуулсан, барьцаа хөрөнгийн баримт бичгийг хуурамчаар үйлдсэнээс барьцаалагчид учирсан хохирлыг бүрэн хариуцаж, хариуцлагыг хууль тогтоомжийн дагуу хүлээнэ.

## Дөрөв. Барьцаалагчийн эрх, үүрэг

4.1 Гэрээнд заасны дагуу барьцааны зүйлийн чанар, арчлан хамгаалалтын нөхцөл болон ашиглалтын байдлыг баримтаар болон газар дээр нь хэдийд ч шалгах

4.2 Зээлийг гэрээний хугацаанд төлөөгүй тохиолдолд барьцаа хөрөнгийг худалдан борлуулах

4.3 Барьцааны зүйлийг худалдан борлуулсан үнийн дүн зээлийн үнийн дүнд хүрэлцэхгүй бол барьцаалуулагчийн бусад хөрөнгөөр зээлийн төлбөр бусад хохирлыг барагдуулах

4.4 Барьцааны зүйлд даатгалын тохиолдол бий болсон бол даатгалын нөхөн төлбөрөөс тэргүүн ээлжинд зээлийн төлбөрийг төлүүлэх

4.5 Зээл бүрэн төлж дууссан үед барьцаа хөрөнгийг чөлөөлж барьцаалуулагчид хүлээлгэн өгөх

4.6 Барьцааны зүйлийн Улсын Бүртгэлийн гэрчилгээг гэрээний үүргээ бүрэн биелүүлэх хүртэл хугацаанд өөрийн эзэмшилд хадгалах

## Тав. Барьцааны зүйлээр хохирол барагдуулах

5.1 Зээлдэгч нь зээлийн гэрээний үүргээ зөрчсөн, зээл, зээлийн хүүний төлбөрийг зээлийн гэрээний эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлөөгүй эсхүл зээлийн гэрээний хугацаа дуусгавар болсон бол барьцааны зүйлээр зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулах эрх барьцаалагчид үүснэ.

5.2 Хөдлөх хөрөнгийн хувьд: Зээлийн гэрээний үүрэг биелээгүй тохиолдолд барьцаалагдсан хөдлөх хөрөнгийг бүхэлд нь болон хэсэгчлэн үл маргах журмаар барьцаалагчид шилжүүлнэ. Зээлийн гэрээний үүргийг биелэлтийг хангуулах зорилгоор барьцаалагч нь шилжүүлэн авсан барьцаа хөрөнгийг гэрээнд заасан үнээр захиран зарцуулна.

5.3 Үл хөдлөх хөрөнгийн хувьд: Хуульд заасны дагуу шүүхийн журмаар худалдан борлуулна.

ГЭРЭЭНИЙ ТАЛ:

БАРЬЦААЛАГЧ: СУМЫН ЗАСАГ ДАРГА: ......................../Д.ТҮМЭНБАЯР/

БАРЬЦААЛУУЛАГЧ: ............................ /............................../